



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/300

Улаанбаатар хот

### ШУТИС-ийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12.1.4, ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “ШУТИС-ийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. “ШУТИС-ийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны журам”-ыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг хүрээлэн, бүрэлдэхүүн сургууль, захиргааны холбогдох нэгжүүдийн захирал, дарга нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инновацийн газарт даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн ректорын 2012 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/74 дугаар тушаалаар баталсан “Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэхүү тушаалыг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ




НАМНАН

367041823



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2022 оны 11 дүгээр сарын 02 ны өдрийн  
1300 дугаар тушаалын хавсралт

	ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны журам ШУТИС-ЭШ-ЖУ06	Эхний хэвлэлт	2012.04.24
		Өөрчилсөн огноо	2022.11.02
		Өөрчлөлтийн дугаар	1

# ШУТИС-ИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

**Боловсруулсан:**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ГАЗАР

**Хянасан:**

ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

**Дэмжсэн:**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ДЭД ЗӨВЛӨЛ

ШУТИС-ийн ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

**Баталсан:**

ШУТИС-ийн ЗАХИРАЛ



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2022 оны 11 дүгээр сарын 02 ны өдрийн  
А/300 дугаар тушаалын хавсралт

## АГУУЛГА

АГУУЛГА.....	3
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	4
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.....	4
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	4
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	5
ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....	5
ЗУРГАА. ХҮРЭЭЛЭН БАЙГУУЛАХ, БҮРТГҮҮЛЭХ, ТАТАН БУУЛГАХ.....	7
ДОЛОО. ХҮРЭЭЛЭНГИЙН УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	7
НАЙМ. ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	7
ЕС. ХҮРЭЭЛЭНГИЙН ТӨСӨВ, САНХҮҮ.....	8
АРАВ. ХАРИУЦЛАГА БА БУСАД.....	9
ХАВСРАЛТ 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ.....	10



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн  
дугаар тушаалын хавсралт

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн /цаашид “Их сургууль” гэх/ дэргэд Эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулах, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх, үүрэг, төсөв, санхүү, хариуцлага, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлэх дүгнэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Салбарын шинжлэх ухааны бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгааг боловсруулж хэрэгжүүлэх, техник технологи, инновацыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, шинэ технологийг зүгшрүүлэх, дамжуулах, судалгаа, туршилт, зохион бүтээх ажил эрхлэх зорилгоор Их сургуулийн дэргэд эрдэм шинжилгээний хүрээлэн (цаашид “Хүрээлэн” гэх) байгуулан ажиллуулж болно.
- 1.3. Хүрээлэнгийн нийтлэг зарчим:
  - 1.3.1. Хууль ёсыг дээдлэх;
  - 1.3.2. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
  - 1.3.3. Судалгааны болон судлаачийн ёс зүйг эрхэмлэх;
  - 1.3.4. Туршилт, судалгаа, инновацийн нэгдлийг хангах.

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Харьяа болон бүрэлдэхүүн хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, зохион бүтээх үйл ажиллагаанд оролцогч эрдэм шинжилгээний ажилтан, удирдах ажилтан, судлаач багш, ахисан түвшний суралцагч, сонирхогч талуудад хамаарна.
- 2.2. Хүрээлэнг байгуулах, үйл ажиллагаа явуулах, түүний үр дүнг тооцох, өөрчлөх, татан буулгах үйл явцыг хамарна.

## ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

Хүрээлэн нь үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль, тогтоомж болон Их сургуулийн дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллана.

- 3.1. Дээд боловсролын тухай хууль
- 3.2. Иргэний хууль
- 3.3. Инновацийн тухай хууль
- 3.4. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
- 3.5. Авлигын эсрэг хууль
- 3.6. Төсвийн тухай хууль
- 3.7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
- 3.8. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм
- 3.9. ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм
- 3.10. ШУТИС-2030 Стратеги төлөвлөгөө
- 3.11. ШУТИС-ийн дүрэм, холбогдох журмууд



## ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1. **Эрдэм шинжилгээний хүрээлэн:** Эрдэм шинжилгээ, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг хуулийн этгээдийг;
- 4.2. **Харьяа хүрээлэн:** Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан Их сургуулийн нэгжийг;
- 4.3. **Бүрэлдэхүүн хүрээлэн:** Бүрэлдэхүүн сургуулийн санаачилгаар байгуулагдсан, салбарын тэргүүлэх чиглэлээр судалгаа, боловсруулалтын үйл ажиллагаа явуулдаг Их сургуулийн нэгжийг;
- 4.4. **Үүсгэн байгуулагч:** Монгол улсын Засгийн газар, Их сургуулийг;
- 4.5. **Судлаач:** Эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд оролцогч эрдэм шинжилгээний ажилтан, судлаач багш, ахисан түвшний оюутанг.

## ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1. **Удирдах зөвлөл** нь хүрээлэнгийн талаар Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг хэлэлцэж, хүрээлэнг байгуулах, өөрчлөх, татан буулгах талаар шийдвэр гаргана.
- 5.2. **ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл** нь бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн саналыг хэлэлцэж, шийдвэр гаргах үүрэг хүлээнэ.
- 5.3. **Эрдэм шинжилгээ, инновац, хамтын ажиллагааны дэд зөвлөл**
  - 5.3.1. Хүрээлэнгийн захирлын үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж, дүгнэнэ.
  - 5.3.2. Хүрээлэн дээр хэрэгжиж буй төслийн явц, үр дүнг хэлэлцэж, шийдвэр гаргана.
- 5.4. **Их сургуулийн захирал**
  - 5.4.1. Хүрээлэнгийн захирлыг томилох, чөлөөлөх болон холбогдох бусад асуудлаар тушаал гаргана.
  - 5.4.2. Хүрээлэнгийн захиралтай хөдөлмөрийн болон, үр дүнгийн гэрээ байгуулна.
- 5.5. **Бүрэлдэхүүн сургууль**
  - 5.5.1. Бүрэлдэхүүн хүрээлэнг байгуулах санал, бүтэц, дүрэм болон хүрээлэн дээр хэрэгжиж буй төсөлтэй холбоотой асуудлыг өөрийн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ.
  - 5.5.2. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.
- 5.6. **Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж**
  - 5.6.1. Хүрээлэн, их сургуулийн хамтын ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, удирдлагаар хангана.
  - 5.6.2. Хүрээлэнгийн үйл ажиллагааг таниулан сурталчилах үйл ажиллагааг хүрээлэнтэй хамтран зохион байгуулна.
- 5.7. **Технологи дамжуулах төв** нь хүрээлэнгийн оюуны бүтээлийг дэмжих, технологи дамжуулах үйл явцыг зохион байгуулах, удирдлагаар хангана.
- 5.8. **Хүрээлэн** нь дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:
  - 5.8.1. Хүрээлэнгийн салбар, нэгжийн ажилтнуудыг хүрээлэнгийн захирал томилно.



- 5.8.2. Олон улсын болон дотоод, гадаадын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай бие даан гэрээ хэлцэл байгуулж, гэрээт ажил, захиалгат төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.8.3. Их сургуулийн эрдэм шинжилгээ, инновацын санхүүжилттэй шилдэг бүтээлийн шалгаруулалт болон төслийн уралдаанд оролцож дэмжлэг авна.
- 5.8.4. Олон улсын чансаа өндөртэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэх, гарааны компани байгуулах, технологи лицензлэх зэрэг үйл ажиллагаанд Их сургуулиас мэргэжил, арга зүйн дэмжлэг авна.
- 5.8.5. Их сургуулийн удирдлагын мэдээллийн систем, номын санг ашиглах, электрон шуудангийн хаяг (must.edu.mn) нээлгэх, тус Их сургуулийн албан ёсны вэб хуудсанд мэдээлэл оруулна.
- 5.8.6. Хүрээлэнгийн эрдэмтэд бүрэлдэхүүн сургуулийн Магистрын төгсөлтийн ажил хамгаалуулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж болно.
- 5.8.7. Эрдэм шинжилгээний хурал, уулзалт, семинар, үзэсгэлэн болон бусад арга хэмжээ, үйл ажиллагаа явуулахад Их сургуулийн анги, танхим, лабораторийг ашиглана.
- 5.8.8. Хүрээлэнгийн эрдмийн зэрэг, цолтой эрдэм шинжилгээний ажилтан, судлаачид Их сургуулийн бакалавр, магистр, доктор оюутны судалгааны ажлын удирдагч, зөвлөхөөр ажиллаж болох бөгөөд “ШУТИС-д магистр, докторын сургалт явуулах, зэрэг хамгаалуулахад баримтлах журам”-ын холбогдох заалтыг үндэслэн зохицуулна.
- 5.8.9. Харьяа хүрээлэнгийн эрдмийн зэрэг, цолтой эрдэм шинжилгээний ажилтан, судлаачид бүрэлдэхүүн сургуульд гэрээт багшаар ажиллаж болох бөгөөд “ШУТИС-д мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын холбогдох заалтыг үндэслэн зохицуулна.
- 5.9. **Хүрээлэн** нь дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:
- 5.9.1. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, судлаачид судалгааны ажлын чиглэлээр олон улсад хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүл болон WOS, Scopus-д бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байна.
- 5.9.2. Их сургуулийн профессор багш нар болон ахисан түвшний оюутан, судлаач нартай хамтран гэрээт ажил, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.9.3. Их сургуулийн профессор, багш нарын судалгааны ажлыг дэмжиж, өөрийн лабораторийг үнэ төлбөргүй ашиглах боломжоор хангаж, хамтарсан судалгаа, туршилтын ажил гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.9.4. Хүрээлэн нь үйл ажиллагааны мэдээллээ Их сургуулийн мэдээллийн сан, өөрийн вэб хуудсанд тухай бүр оруулж үр дүн, тайланг Эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид заасан хугацаанд хүргүүлж, тайлагнана.
- 5.9.5. Хүрээлэн нь Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.



### **ЗУРГАА. ХҮРЭЭЛЭН БАЙГУУЛАХ, БҮРТГҮҮЛЭХ, ТАТАН БУУЛГАХ**

- 6.1. Их сургуулийн дэргэд харьяа хүрээлэн байгуулах зөвшөөрлийг Засгийн газрын тогтоолоор, бүрэлдэхүүн хүрээлэн байгуулах зөвшөөрлийг бүрэлдэхүүн сургуулийн санал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөлийн шийдвэрээр байгуулна.
- 6.2. Хүрээлэн нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ авснаар үйл ажиллагаагаа явуулна.
- 6.3. Хүрээлэнг өөрчлөн байгуулах (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), татан буулгах асуудлыг үүсгэн байгуулагчийн саналыг үндэслэн холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

### **ДОЛОО. ХҮРЭЭЛЭНГИЙН УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 7.1. Хүрээлэнгийн захирлыг ШУТИС-ийн захирлын тушаалаар 3 жилийн хугацаатай томилох ба үр дүнгийн гэрээний биелэлтийг үндэслэн дахин нэг удаа 3 жилийн хугацаагаар ажиллуулж болно.
- 7.2. Хүрээлэнгийн захирлын албан тушаалыг Их сургуулийн захиргааны болон бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдах ажилтнууд хавсран гүйцэтгэхгүй.
- 7.3. Хүрээлэнгийн захирал нь ШУТИС-ийн захиралтай жил бүр хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулна.
- 7.4. Хүрээлэнгийн захирлын үр дүнгийн гэрээний биелэлтийг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инновац, хамтын ажиллагааны дэд зөвлөл хэлэлцэж, удирдамжийн дагуу үнэлж, дүгнэнэ.
- 7.5. Хүрээлэнгийн захирал нь ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн байх бөгөөд Их сургуулийн эрдэм шинжилгээ, технологи, инновацтай холбогдолтой асуудал хэлэлцэх үед Захирлын зөвлөлийн хуралдаанд оролцоно.
- 7.6. Харьяа хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн хүрээлэнгийн эрдэмтэд, төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох салбарын тэргүүлэх эрдэмтэд, үйлдвэрлэл, бизнесийн байгууллагын төлөөлөл орж болох бөгөөд гишүүдийн 1/5-ээс доошгүй хувь нь ШУТИС-ийн эрдэмтэн, профессор, багш байна.
- 7.7. Харьяа хүрээлэнгийн саналыг үндэслэн Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг ШУТИС-ийн захирал батална.
- 7.8. Бүрэлдэхүүн хүрээлэнгийн дотоод бүтэц, дүрмийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн ШУТИС-ийн захирал батална.
- 7.9. Хүрээлэн нь үйл ажиллагааныхаа чиглэлээр эрдэм шинжилгээний төв, судалгааны лаборатори, зохион бүтээх товчоо, гарааны компани байгуулан ажиллуулж болно.

### **НАЙМ. ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 8.1. Хүрээлэн нь Монгол улсын болон Их сургуулийн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдсан урт болон дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй байна.



- 8.2. Хүрээлэн нь улсын төсвийн, төрийн өмчийн, хувийн хэвшлийн байгууллагын санхүүжилтээр суурь, хавсарга судалгаа, шинжлэх ухаан, технологи, инновацийн төсөл, захиалгат ажил, эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил, технологи дамжуулах, гэрээт ажил, олон улсын төслийг гэрээгээр гүйцэтгэнэ.
- 8.3. Судалгааны чиглэлийн хүрээнд олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтарсан төсөл, гэрээт ажил, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 8.4. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудын судалгааны бүтээл, үр дүнг хянан магадлагаа хийгддэг дотоодын болон олон улсын эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд тогтмол хэвлэн нийтлүүлж олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 8.5. Үндэсний болон олон улсад магадлан итгэмжлэгдсэн лаборатори, салбар дундын судалгааны лабораторийг хөгжүүлнэ.
- 8.6. Хүрээлэнгийн судалгааны материаллаг баазыг түшиглэн Их сургуулийн ахисан түвшний оюутан, багш судлаачидтай хамтарсан туршилт, судалгаа хийнэ.
- 8.7. Эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, судлаачдыг чадавхжуулах сургалт, семинар, хэлэлцүүлгийг Их сургуультай хамтран болон бие даан зохион байгуулна.
- 8.8. Хүрээлэн нь судлаачдын оюуны бүтээлийг бүртгүүлэх, хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар Их сургууль, төсвийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагааг дэмжиж ажиллана.

### ЕС. ХҮРЭЭЛЭНГИЙН ТӨСӨВ, САНХҮҮ

- 9.1. Хүрээлэн нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллана.
- 9.2. Харьяа хүрээлэн нь эрдэм шинжилгээний ажилтны цалин, нийгмийн даатгал, татвар, байр ашиглалт зэрэг тогтмол зардлыг улсын төсвөөс, үйл ажиллагаагаа өөрийн нэмэлт орлогоор санхүүжүүлэх зарчмыг баримтлан ажиллана.
- 9.3. Харьяа хүрээлэнгийн ажилтнуудын цалингийн хэмжээг Засгийн газраас тогтоосон жишгийг баримтлан Хүрээлэнгийн захирал дагаж мөрдөнө.
- 9.4. Бүрэлдэхүүн хүрээлэн нь эрдэм шинжилгээний орлогоо өөрөө бүрдүүлэх бөгөөд хүрээлэнгийн захирал ажилтнуудын цалинг дараах байдлаар тогтооно. Үүнд:
  - 9.4.1. Их сургуулийн профессор, багш, судлаачид нь бүрэлдэхүүн хүрээлэнд хавсарч ажилласан тохиолдолд хүрээлэнгийн захирал гэрээгээр ажиллуулж, цалинг эрдэм шинжилгээний нэмэлт орлогоос;
  - 9.4.2. Гадны байгууллагаас эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдыг ажиллуулбал хүрээлэнгийн захирал цалингийн хэмжээг гэрээгээр зохицуулах ба цалинг эрдэм шинжилгээний нэмэлт орлогоос тооцож олгоно.
- 9.5. Хүрээлэнгээс суралцаж буй магистрант, докторантын туршилт судалгааны ажлын кредитийн төлбөрийг “ШУТИС-д магистр, докторын сургалт явуулах, зэрэг хамгаалуулахад баримтлах журам”, “ШУТИС-д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын холбогдох заалтуудыг үндэслэн тооцуулж болно.





- 9.6. Харьяа хүрээлэн санхүүгийн тайлангаа санхүүжүүлэгч байгууллага болох ШУТСан, БШУЯ-д, бүрэлдэхүүн хүрээлэн Их сургуулийн холбогдох нэгжид тус тус тайлагнана.
- 9.7. Хүрээлэнгийн төлбөрт үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг Хүрээлэнгийн саналыг үндэслэн ШУТИС-ийн захирлын тушаалаар баталж, мөрдөнө.
- 9.8. Хүрээлэн нь өөрийн эрдэм шинжилгээний үйл ажиллагааны санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг бүрдүүлнэ.

### АРАВ. ХАРИУЦЛАГА БА БУСАД

- 10.1. Хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод үйл ажиллагаанд Их сургуулийн холбогдох нэгжээс төлөвлөгөөний дагуу хяналт, шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт гаргана.
- 10.2. Улсын захиалгат төсөл, суурь судалгааны төсөл, шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй төслийн санал, төслийн судалгааны ажлын арга зүй, явц, үр дүн, тайланг харьяа хүрээлэн нь өөрийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлөөр, бүрэлдэхүүн хүрээлэн нь бүрэлдэхүүн сургуулийнхаа Эрдмийн зөвлөлөөр тус тус хэлэлцүүлнэ.
- 10.3. Хүрээлэн дээр хэрэгжиж буй төслийг дараах тохиолдолд Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инновац, хамтын ажиллагааны дэд зөвлөлөөр хэлэлцүүлнэ. Үүнд:
- 10.3.1. ШУТИС-ийн санхүүжилттэй төслийн явц, эцсийн тайлан,
- 10.3.2. Гэрээний эрх үүрэг нь зөрчигдсөн, хэрэгжилт нь хангалтгүй байгаа төслүүд.
- 10.4. Монгол улсын холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчсөн, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг болон үр дүнгийн гэрээгээ хангалтгүй биелүүлсэн Хүрээлэнгийн захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шийдвэрийг ШУТИС-ийн захирал гаргана.
- 10.5. Харьяа хүрээлэнгийн ажилтнуудын судалгааны арга барил, ур чадвар, ажлын үр дүнгийн аттестатчиллыг 4 жил тутамд шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох журмын дагуу зохион байгуулна.
- 10.6. Бүрэлдэхүүн хүрээлэнгийн ажилтнуудын мэргэжил, ур чадвар, ажлын үр дүнгийн аттестатчиллыг 4 жил тутамд Эрдэм шинжилгээ хариуцсан нэгжээс эрхлэн зохион байгуулж, дүгнэнэ.
- 10.7. Энэхүү журамтай холбоотой гарсан аливаа маргааныг харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол улсын холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлүүлнэ.



## ХАВСРАЛТ 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

Оролцооны тайлбар: **[R]** - Хариуцан хийж, гүйцэтгэх; **[A]** - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; **[C]** - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрах оролцох; **[I]** – Алхмын гаралтыг мэдээлэх

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо (RACI)			
				X З	ЭШ ХН	ЭШИ ХАД З	Ш З
1	Дээд газрын шийдвэр	1. Хуулийн этгээдээр бүртгүүлэх	Хүрээлэнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ		R	A	
2	Хүрээлэнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ	2. Хүрээлэнгийн захирлыг томилох	ШУТИС-ийн захирлын тушаал		R		A
3	ШУТИС-ийн захирлын тушаал	3. Жилийн үр дүнгийн гэрээ байгуулах	ШУТИС-ийн захиралтай байгуулсан гэрээ	R	C		A
4	Монгол улсын болон ШУТИС-ийн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд	4. Урт болон дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Урт болон дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөө	R	C		A
5	Урт болон дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөө	5. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх/ үйл ажиллагааг явуулах	Үйл ажиллагааны мэдээ, тайлан	R/ A	C	C	I
6	ШУТИС-ийн захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээ  Үйл ажиллагааны мэдээ, тайлан	6. Үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж, дүгнэх  Үнэлгээ хангалттай эсэх  Үгүй	Үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээ	C	C	R	A
7	Үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээ	7. Холбогдох журмын дагуу хариуцлага тооцох	Авсан арга хэмжээний мэдээлэл		R		A

\*XЗ – хүрээлэнгийн захирал

\*ЭШХН – эрдэм шинжилгээ хариуцсан нэгж

\*ЭШИХАДЗ - эрдэм шинжилгээ, инновац, хамтын ажиллагааны дэд зөвлөл

\*ШЗ – ШУТИС-ийн захирал